



Аудитын код: САГ-2018/11/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Хосжаргал

Утас: 261885 Цахим хаяг: hkosjargalts@audit.gov.mn

Аудитор Б.Сэржмядаг

Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn

Аудитор П.Амарсанаа

Утас: 261628 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn

Улаанбаатар хот



Агуулга

1	АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН	3
2	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	6
3	АУДИТЫН ТАЙЛАН	8
3.1	Оршил.....	8
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг хариуцлага	8
3.3	Байгууллагын зорилго үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	9
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн...	9
3.5	Дотоод аудит	10
3.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
3.7	Шилэн дансны мэдээлэл	11
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	11
2.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	11
2.9.1	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал	11
3.8	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
2.10	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд	12
2.11	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	13
3.9	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.10	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл тайлбар.....	13
3.11	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	14
3.12	Аудитын үр өгөөж.....	14
4	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	15
4.1	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчил.....	16
4.2	Асуудал 2: Зардлын зарцуулаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлэх	16
4.3	Авлагыг барагдуулах арга хэмжээ авах.....	17
4.4	Цалингийн ангилал зэрэглэл буруу тогтоосон.....	17
5	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	18
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	18
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	19
5.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан.....	20
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	21
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22
5.6	Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	24
6	ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОР, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ М.ЭНХ-АМГАЛАН
ТАНАА

2018.04.25 № 1023

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.00.20\Bichig_KhuregiYawsan_Bichig\2018\04\25\SAG12 Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

070410

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР



3 Аудитын тайлан

3.1 Оршил

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий прокурор, хууль цаазын тэргүүн зөвлөх М.Энх-Амгалан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд авлага, цалингийн ангилал, харьяа газруудад илэрсэн зөрчилд өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн аудитын тайлангийн журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 04 дүгээр сарын 5-аас 2018 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал, аудитор Б.Сэржмядаг, П.Амарсанаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын



Ерөнхий прокурорын 2018 оны 4 дүгээр сарын 04-ий өдрийн 1/1313 тоот албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Үндсэн хуулиар Прокурорын байгууллагыг "Монгол Улсын төрийн байгуулал" гэсэн гуравдугаар бүлгийн "Шүүх эрх мэдэл" гэсэн хэсэгт хамааруулан 56 дугаар зүйлийн 56.3-д "Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно" гэж заасны дагуу 1993 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Прокурорын байгууллагын тухай хуулийг батлан гаргаж 2017 он хүртэлх хугацаанд 8 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ.

2017 оны шинэчлэн батлагдсан Прокурорын тухай хуульд үйл ажиллагааны үндсэн зарчим, хуульд заасан зарим нэр томъёог оновчтой болгох, эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд эрүүгийн хууль тогтоомжийн төслүүдтэй уялдуулах, прокурорын байгууллагын харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг харьцуулан дүгнэж, үйл ажиллагааны хариуцлагатай байдлыг хангах, бусад байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн үндсийг бий болгох, прокурор үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгааг дээшлүүлэх, албан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо зэргийг тодорхой зохицуулж өгсөн ба 15 зүйл бүхий 20 заалтаар үндсэн чиг үүргийг тодорхойлжээ.

Монгол Улсын Ерөнхий прокурорын 2017 онд хэрэгжүүлсэн зарим хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Хэрэг бүртгэлийн ажиллагаанд тавих хяналт 100 хувь;
- Ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын хүрээнд хийх шалгах, танилцах ажиллагааны тоо 800 төлөвлөснөөс 952 гүйцэтгэлтэй буюу 119 хувь;
- Хорих анги, цагдан хорих байрын үйл ажиллагаатай биечлэн танилцах тоо 6015 төлөвлөснөөс 6017 гүйцэтгэлтэй буюу 100 хувийн тус тус биелэлттэй байна.

Мөн Төсвийн тухай хуульд зааснаар 1 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээ төлөвлөснөөс 99.98 хувийн биелэлттэй ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж баримтжуулсан.

3.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН


Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай болон, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Монгол Улсын Ерөнхий прокурорын зүгээс тавьж буй дотоод аудитыг үнэлж баримтжууллаа.

Дотоод аудитыг талаарх гол асуудал, дүгнэлтийг тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 чиглэлээр түүвэр байдлаар аудитын 25 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа.

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилдэй зарим үйл асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.



Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад салбарын хэмжээнд 2016 онд боловсруулж Монгол Улсын Ерөнхий прокурорын 2017 оны А/28 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэж байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм ашиглажээ.

3.5 Дотоод аудит

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод аудитыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд хэвийн гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод аудитыг үр нөлөөгүй гэж үнэллээ.

Монгол Улсын Ерөнхий прокурорын 2017 оны А/08 дугаар тушаалаар шинэчлэн баталсан бүтцэд дотоод аудитын орон тоо батлагдсан боловч 2017 онд тус албан тушаалд хүн томилогдон ажиллаагүй, дотоод аудиторын ажлын төлөвлөгөө гаргаагүй.

Мөн дотоод аудитор нь 2016 оны 6 сард ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш хүн томилогдоогүй ба салбарын хэмжээнд 2 дүүргийн прокурорын байгууллагад санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын хяналт шалгалтыг хөрөнгө оруулалтын нягтлан бодогч хийсэн ба бусад харьяа газруудад дотоод хяналт шалгалт хийгдээгүй байгаа нь дотоод аудит хангалтгүй сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

3.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Улсын ерөнхий прокурорын төсвийн багцад 2017 онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 5 арга хэмжээ түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт 26,723.3 сая төгрөг, үүнээс урсгал зардалд 26,635.0 сая, хөрөнгийн зардалд 88.3 сая баталсан ба гүйцэтгэл 99.97 хувь буюу 26,715.6 сая төгрөгийн биелэлттэй байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсөвт зардлын ерөнхий ангиллаар зардал хэтрээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр, арга хэмжээгээр гаргаагүй байсныг аудит хийх хугацаанд гаргаж өгсөн.

Мөн нэмэлт санхүүжилтээр тайлант онд 232.9 сая төгрөг, урьд оны үлдэгдэл 3.8 сая төгрөг нийт 236.7 сая төгрөг төвлөрснөөс урсгал зардалд 221.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 15.0 сая төгрөгийг зарцуулсан байна.



3.7 Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын Ерөнхий прокурор төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Монгол Улсын Ерөнхий прокурор өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

- Дараа жилийн төсвийн төсөл (бүтэн жилээр)
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (хагас, бүтэн жилээр, улирал бүр, сар бүр)
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (тухай бүр)
- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (хагас, бүтэн жилээр)
- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (хагас, бүтэн жилээр)
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (тухай бүр)
- Санхүүгийн тайлан (хагас, бүтэн жилээр)
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (бүтэн жилээр)
- Байгууллагын батлагдсан төсөв (бүтэн жилээр) зэрэг болно.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд зөрчил дутагдал илрээгүй байна.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 15 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 25 нарийвчилсан болон хяналтын горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

3.9.1 Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 42 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 27 санхүүгийн тайланд зөрчилгүй, 1 санхүүгийн тайланд хязгаарлалттай, 9 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, 5 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Аудитаар нийт 620.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 390.2 сая төгрөгийн алдааг залруулж 2.4 сая төгрөгийн 3 акт тогтоож, 20.2 сая төгрөгийн 3 албан шаардлага, 207.6 сая төгрөгийн 46 зөвлөмж өгсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад чиглэгдсэн дотоод аудитын ажлыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах, харьяа газруудын акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд нэгтгэдэг 3 байгууллага нэгжид тусвэр хөлбөмбөгөөр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд аудитын явцад нийт 63.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 13.3 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 50.0 сая төгрөгийн

зөрчлийг арилгах 4 зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв. Эдгээр зөвлөмжийг нэгтгэж, ажлын баримт материалд хавсарган Төсвийн ерөнхийлөн захирагчид менежментийн захидлаар хүргүүлэв. Үүнд:

- Цалингийн зардлын зарцуулаагүй үлдэгдлээс Татварын хэлтэст 19.3 сая төгрөг, Нийгмийн даатгалын хэлтэст 16.3 сая төгрөг нийт 35.6 сая төгрөгийн шилжүүлж авлагаар тусгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, илүү шилжүүлсэн цалингийн зарцуулаагүй үлдэгдлийн улсын төсөвт буцаан төвлөрүүлэх, зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

- Тамгын газрын санхүүгийн тайланд өмнөх онуудад үүссэн 0.7 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн прокурорын газрын хугацаа хэтэрсэн цалингийн авлага 1,4 сая төгрөгийг барагдуулах талаар санаачлагатай ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах", гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 6.4.8, 7.7-д заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллах, зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

- Монгол Улсын Ерөнхий прокурорын 2011 оны тушаалаар харьяа байгууллагуудын төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын ангилал зэрэглэлийг буруу тогтоосноос цалин, нэмэгдэл, шимтгэлийн хамт нийт 12.3 сая төгрөгийг тайлант онд илүү олгосон байгаа нь Засгийн газрын 2007 оны "Төрийн болон үйлчилгээний албан тушаалын ангилал зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 354 дүгээр тогтоол, 2014 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" 332 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, өмнөх оны зөвлөмж биелүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын тогтоолуудыг тус тус хэрэгжүүлэн ажиллах, зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар анхаарал татах асуудал гараагүй болно.

3.11 ЗАВСРЫН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд дараах чиглэлээр нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Цалин, нэмэгдэл болон цалингийн ангилал, зэрэглэл тогтоолт, цалингийн бодолт давтан шалгах
- Харьяа байгууллагууд төсвийн зарцуулалтыг эдийн засгийн ангиллын дагуу зориулалтаар зарцуулж буй эсэхийг түүвэрлэн үзэх.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Нэгтгэсэн тайланд Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 683.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 390.2 сая төгрөгийн алдааг залруулж, 2.4 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 20.2 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 257.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 49 зөвлөмж хүргүүлэв.

3.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар бүртгэл тайлагнал, авлага, өр төлбөр, харьяа газруудын илэрсэн зөрчилтэй холбоотой 469.0 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн байна. Үүнээс үндсэн хөрөнгөтэй холбоотой 5 сая төгрөгийн зөвлөмж 100 хувь, цалингийн дансны бичилт, үйлчилгээний ажилтнуудын цалингийн ангилал буруу тогтоосон 210.9 сая төгрөгийн зөвлөмжийн биелэлт 30 хувь, харьяа газруудын зөвлөмж 92.3 хувь нийт зөвлөмж 64.1 хувийн биелэлттэй байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас Тамгын газар, Эрүүгийн хэргийн төв архивын 2017 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж 61.8 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илрүүлж 9.3 сая төгрөгийн алдааг залруулж, 52.5 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн. Үүнээс 0.7 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар өгсөн зөвлөмжийг биелүүлж ажиллаагүй, урьд онд батлагдсан төсөвгүй байхад томилолтоор ажиллаж 15.8 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн зөрчилд өгсөн зөвлөмжийг дотоод томилолтын батлагдсан төсвөөс барагдуулж зөвлөмжийн биелэлт 100 хувь, бага үнэтэй түргэн элэгдэх зардал 36.0 сая төгрөгөөр хэтэрч үүнээс 12.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан зөвлөмжийн биелэлт 50 хувьтай нийт зөвлөмжийн биелэлт 66.6 хувьтай байна.


Мөн Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас төсвийн шууд захирагчийн хуулийн хугацаанд Тамгын газар, Эрүүгийн хэргийн төв архивын 2017 оны санхүүгийн тайланд түүврийн аудит хийж аудитаар нийт 152.3 сая төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс 88.3 сая төгрөгийн 2 алдаа, зөрчлийг залруулж, 64.0 сая төгрөгийн зөрчлийг арилгахаар 6 зөвлөмж өгснийг аудитын явцад хэрэгжилтийг гаргуулан авлаа. Үүнд:

Төсвийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан 32.4 сая төгрөг, дэмжих болон анхан шатны баримт бүрдэл хангалтгүй 8.3 сая төгрөг нийт 40.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллана гэсэн зөвлөмжийн биелэлт ирүүлсэн, цалингийн зарцуулаагүй үлдэгдлийг татвар, нийгмийн даатгалын байгууллагад илүү шилжүүлсэн 22.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх зөвлөмжийг 100 хувь, 2003-2004 онд үүсэн 0.7 сая төгрөгийн авлагыг барагдуулах зөвлөмжийг биелүүлээгүй зөвлөмжийн биелэлт 83.3 хувьтай байна.

3.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Өмнөх оны зөвлөмж 64.1 хувийн биелэлттэй, 2017 оны завсрын аудитаар 61.8 сая төгрөг, түүврийн аудитаар 152.3 сая төгрөг нийт 214.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн, дотоод хяналт төлөвлөлтийн үед үр нөлөөгүй байгаа зэргийг үндэслэн материаллаг байдлын хувийг 1 хувиар сонгож үр дүнгийн тайлангийн нийт зардал 28,047.6 сая төгрөгийн 1 хувь буюу 280.5 сая төгрөгөөр тогтоолоо. Гүйцэтгэлийн үед материаллаг байдалд өөрчлөлт ороогүй ба төрийн аудитын байгууллага болзошгүй гэж үзсэн ба зөрчилгүй алдаа, зөрчил илрээгүй болно.



3.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, нэгтгэсэн санхүүгийн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3.16 АУДИТЫН ҮР ӨГӨӨЖ

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 35.6 сая төгрөгийн үр өгөөжийн тооцооллыг хийж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагаар баталгаажуулсан болно.



4 Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын санхүүгийн ажилтануудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



4.1 Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчил

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 42 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 27 санхүүгийн тайланд зөрчилгүй, 1 санхүүгийн тайланд хязгаарлалттай, 9 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, 5 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Аудитаар нийт 620.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 390.2 сая төгрөгийн алдааг залруулж 2.4 сая төгрөгийн 3 акт тогтоож, 20.2 сая төгрөгийн 3 албан шаардлага, 207.6 сая төгрөгийн 49 зөвлөмж өгсөн байна.

Эрсдэлүүд:

Бүртгэлээр тавих хяналт сулрах, хууль, дүрэм, журам мөрдөгдөхгүй байх.

ҮАГ-ын зөвлөмж:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад чиглэгдсэн дотоод аудитын ажлыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах, харьяа газруудын акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажиллах зөвлөмж өгөх.

Биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирлүүлэх

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.

4.2 Асуудал 2: Зардлын зарцуулаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлэх

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт:

Цалингийн зардлын зарцуулаагүй үлдэгдлээс Татварын хэлтэст 19.3 сая төгрөг, Нийгмийн даатгалын хэлтэст 16.3 сая төгрөг нийт 35.6 сая төгрөгийн шилжүүлж авлагаар тусгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд:

Төсвийн зардал хэтрэх, хууль, дүрэм, журам мөрдөгдөхгүй байх


ҮАГ-ын зөвлөмж:

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, илүү шилжүүлсэн цалингийн зарцуулаагүй үлдэгдлийн улсын төсөвс төвлөрүүлэх, зөвлөмж өгөх

Биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.



4.3 Авлагыг барагдуулах арга хэмжээ авах

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт:

Тамгын газрын санхүүгийн тайланд өмнөх онуудад үүссэн 0.7 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн прокурорын газрын хугацаа хэтэрсэн цалингийн авлага 1,4 сая төгрөгийг барагдуулах талаар санаачлагатай ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах", гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд:

Найдваргүй, олон жил болсон авлага нэмэгдэх, төсвийн зохистой удирдлага хэрэгжихгүй байх

ҮАГ-ын зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8, 7.7-д заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллах, зөвлөмж өгөх.

Биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.

4.4 Цалингийн ангилал зэрэглэл буруу тогтоосон

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт:

Монгол Улсын Ерөнхий прокурорын 2011 оны тушаалаар харьяа байгууллагуудын төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын ангилал зэрэглэлийг буруу тогтоосноос цалин, нэмэгдэл, НДШ-ийн хамт нийт 12.3 сая төгрөгийг тайлант онд илүү олгосон нь Засгийн газрын 2007 оны "Төрийн болон үйлчилгээний албан тушаалын ангилал зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 354 дүгээр тогтоол, 2014 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" 332 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, өмнөх оны зөвлөмж биелүүлээгүй байна.

Эрсдэлүүд:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хяналт сул

ҮАГ-ын зөвлөмж:

Засгийн газрын тогтоолуудыг тус тус хэрэгжүүлэн ажиллах

Биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

5.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	684,350.9	3,226,475.7
Мөнгөн хөрөнгө	254,259.7	340,898.8
Авлага	31,259.8	84,346.0
Урьдчилгаа	1,000.0	11,754.3
Бараа материал	397,831.3	383,601.2
Бусад эргэлтийн хөрөнгө	0.0	2,405,875.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	19,387,802.2	18,585,007.5
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	19,387,802.2	18,585,007.5
Биет хөрөнгө	19,372,850.4	18,570,713.5
Биет бус хөрөнгө	14,951.8	14,294.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	20,072,153.1	21,811,483.3
НИЙТ ӨР ТӨЛБӨР	476,152.8	334,783.4
Богино хугацаат өр төлбөр	476,152.8	334,783.4
Өглөг	309,135.0	43,300.9
Урьдчилж орсон орлого	167,017.8	291,482.5
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	19,596,000.2	21,476,699.8
Засгийн газрын хувь оролцоо	19,596,000.2	21,476,699.8
Засгийн газрын оруулсан капитал/ Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,625,705.8	12,625,705.8
Хуримтлагдсан үр дүн	5,076,803.8	6,956,603.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,893,490.6	1,894,391.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	20,072,153.1	21,811,483.3



5.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	17,930,934.2	29,827,271.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	110,453.1	2,871,964.7
Нийтлэг татварын бус орлого	110,453.1	2,871,964.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,820,481.0	26,955,307.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	19,856,146.8	28,046,381.3
УРСГАЛ ЗАРДАЛ	19,856,146.8	28,046,381.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,564,202.4	27,457,951.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,544,035.7	20,977,791.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,395,617.1	2,310,925.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	840,541.5	838,643.6
Хангамж, бараа материалын зардал	2,324,713.4	1,043,650.2
Нормативт зардал	21,388.6	29,614.5
Эд хогшил, урсгал засварын зардал	281,177.4	517,251.7
Томиллолт, зочны зардал	87,849.8	95,925.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,506.7	68,649.7
Бараа үйлчилгээний бусад зардал	2,014,372.1	1,574,555.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	291,944.5	588,429.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(1,925,212.7)	1,781,833.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	162,273.8	1,160.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(2,087,486.5)	1,780,672.6



5.3 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,193,344.8	0.0	20,193,344.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,493,259.3	0.0	1,493,259.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,686,604.25	0.0	21,686,604.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(3,117.5)	0.0	(3,117.53)
Тайлант үеийн үр дүн	(2,087,486.4)	0.0	(2,087,486.4)
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,596,000.2	0.0	19,596,000.2
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	19,596,000.2	0.0	19,596,000.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	100,754.1	0.0	100,754.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	19,695,126.9	0.0	19,695,126.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(727.1)	0.0	(727.1)
Тайлант үеийн үр дүн	1,780,672.6	0.0	1,780,672.6
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,476,699.8	0.0	21,476,699.8



5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	18,002,979.0	27,346,396.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	152,285.4	353,073.2
Нийтлэг татварын бус орлого	152,285.4	353,073.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,850,693.6	26,993,322.9
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,792,854.7	27,097,121.2
УРСГАЛ ЗАРДАЛ	16,792,854.7	27,097,121.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,054,212.0	26,242,272.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,557,968.4	20,957,962.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,381,013.1	2,304,073.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	829,620.9	851,818.6
Хангамж, бараа материалын зардал	721,887.0	992,223.1
Нормативт зардал	14,487.5	8,205.9
Эд хогшил, урсгал засварын зардал	212,276.1	607,458.6
Томилолт, зочны зардал	70,705.9	111,675.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,037.5	69,783.1
Бараа үйлчилгээний бусад зардал	194,215.3	339,071.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	738,642.6	854,848.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,210,124.3	249,275.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,545,862.2	166,527.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,545,862.	166,527.0
Дотоод эх үүсвэрээр	1,545,862.2	166,527.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,545,862.2)	(166,527.0)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	882.3	3,890.9
Бусад эх үүсвэр	882.3	3,934.7
Санхүүгийн үйл ажиллааны зардал	0.0	43.7
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(334,855.6)	86,639.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	589,115.3	254,259.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	254,259.7	340,898.8

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
		254,259,789.30		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,723,270,700.00	26,715,633,168.33	7,637,531.67	99.97
УРСГАЛ ЗАРДАЛ	26,634,970,700.00	26,627,362,168.33	7,608,531.67	99.97
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,077,459,000.00	26,071,648,018.74	5,810,981.26	99.98
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,950,646,400.00	20,949,599,971.30	1,046,428.70	100.00
Үндсэн цалин	18,376,090,200.00	18,682,930,833.40	(306,840,633.40)	101.67
Нэмэгдэл	1,774,619,900.00	1,596,044,703.90	178,575,196.10	89.94
Унаа хоолны хөнгөлөлт	640,189,700.00	556,970,849.00	83,218,851.00	87.00
Гэрээт ажлын хөлс	159,746,600.00	113,653,585.00	46,093,015.00	71.15
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,306,196,800.00	2,302,212,844.66	3,983,955.34	99.83
Тэтгэврийн даатгал	1,464,372,800.00	1,898,652,585.14	(434,279,785.14)	129.66
Тэтгэмжийн даатгал	209,272,300.00	95,331,855.15	113,940,444.85	45.55
ҮОМШӨ-ний даатгал	167,334,000.00	83,894,187.37	83,439,812.63	50.14
Ажилгүйдлийн даатгал	46,960,900.00	22,449,850.55	24,511,049.45	47.81
Эрүүл мэндийн даатгал	418,256,800.00	201,884,366.45	216,372,433.55	48.27
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	850,776,900.00	850,282,829.79	494,070.21	99.94
Гэрэл, цахилгаан	138,657,200.00	153,633,852.71	(14,976,652.71)	110.80
Түлш, халаалт	566,249,700.00	552,724,695.89	13,525,004.11	97.61
Цэвэр, бохир ус	73,414,400.00	72,519,359.33	895,040.67	98.78
Байрны түрээс	72,455,600.00	71,404,921.86	1,050,678.14	98.55
Хангамж, бараа материалын зардал	984,346,900.00	984,332,156.99	14,743.01	100.00
Бичиг хэрэг	211,510,800.00	212,661,587.00	(1,150,787.00)	100.54
Тээвэр, шатахуун	250,705,200.00	236,738,408.10	13,966,791.90	94.43
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	401,932,600.00	405,192,373.51	(3,259,773.51)	100.81
Ном хэвлэл	2,633,200.00	2,758,381.00	(125,181.00)	104.75
Хог хягдал залуулах, хортон мэргэчдийн утгал, ариутгал	3,593,100.00	3,831,600.00	(238,500.00)	106.64
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	113,972,000.00	123,149,807.38	(9,177,807.38)	108.05
Нормативт зардал	8,205,900.00	8,205,900.00	0.00	100.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,205,900.00	8,205,900.00	0.00	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	573,341,300.00	573,322,453.00	18,847.00	100.00
Багаж, техник, хэрэгсэл	30,094,200.00	30,294,150.00	(199,950.00)	100.66
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			0.00	#DIV/0!
Урсгал засвар	543,247,100.00	543,028,303.00	218,797.00	99.96
Томилолт, зочны зардал	111,805,600.00	111,675,650.00	129,950.00	99.88
Гадаад томилолт	10,000,000.00	30,598,050.00	(20,598,050.00)	305.98
Дотоод албан томилолт	80,117,300.00	59,389,265.00	20,728,035.00	74.43
Зочин төлөөлөгч хүлэн авах	21,688,300.00	21,688,335.00	(35.00)	100.00

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАА ДҮГНЭЛТ

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,902,000.00	68,819,737.00	82,263.00	99.88
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,886,600.00	10,815,864.00	70,736.00	99.35
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,719,500.00	1,719,500.00	0.00	100.00
Даатгалын үйлчилгээ	25,048,500.00	25,048,410.00	90.00	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	6,535,200.00	6,534,125.00	1,075.00	99.98
Тээврийн хэрэгслийн оношлогоо	843,900.00	843,900.00	0.00	100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,257,800.00	18,257,800.00	0.00	100.00
Газрын төлбөр	5,610,500.00	5,600,138.00	10,362.00	99.82
Бараа үйлчилгээний бусад зардал	223,237,200.00	223,196,476.00	40,724.00	99.98
Бараа үйлчилгээний бусад зардал	125,638,800.00	125,627,268.00	11,532.00	99.99
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	97,598,400.00	97,569,208.00	29,192.00	99.97
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	557,511,700.00	555,714,149.59	1,797,550.41	99.68
Бусад урсгал шилжүүлэг	557,511,700.00	555,714,149.59	1,797,550.41	99.68
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	374,869,700.00	373,254,000.00	1,615,700.00	99.57
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	182,642,000.00	182,460,149.59	181,850.41	99.90
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	88,300,000.00	88,271,000.00	29,000.00	99.97
Барилга байгууламж	88,300,000.00	88,271,000.00	29,000.00	99.97
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	26,723,270,700.00	26,715,632,198.37	7,638,501.63	99.97
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,723,270,700.00	26,715,632,198.37	7,638,501.63	99.97
Улсын төсвөөс санхүүжих	26,723,270,700.00	26,715,632,198.37	7,638,501.63	99.97
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	340,898,809.37	(340,898,809.37)	
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт	0	86,639,020.07	(86,639,020.07)	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			0.00	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	41	41	0.00	100.00
Төсвийн байгууллага	41	41	0.00	100.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО	984	984	0.00	100.00
Удирдах ажилтан	51	51	0.00	100.00
Гүйцэтгэх ажилтан	763	763	0.00	100.00
Үйлчлэх ажилтан	170	170	0	100.00



5.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	Тайлант оны гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	236,763.0
УРСГАЛ ЗАРДАЛ	221,763.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	213,368.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	945.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,535.8
Хангамж, бараа материалын зардал	6,614.4
Эд хогшил, урсгал засварын зардал	79,915.2
Бараа үйлчилгээний бусад зардал	116,301.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,394.2
Бусад урсгал шилжүүлэг	3,340.5
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,053.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,000
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	232,909.3
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	206,301.8
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,542.0
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,065.4

